



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 1/61

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшиүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Л.Цэдэв – Хууль, эрх зүй хариуцсан  
мэргэжилтэн

Дуудлага худалдааны хөтлөгч: Ц.Нямдорж - Газрын даамал  
Тэмдэглэл хөтлөгч: Д.Мөнхбат - Бэлчээр, газар тариалангийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн дарга /Л.Цэдэв/-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”-ын дагуу тогтоож, зохих журмын дагуу Газрын цахим биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) хаягаар дуудлага худалдааг зохион байгуулах.

б. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

